



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/265.

Ховд

Зарим спорт заал, сургалтын төвийн  
үйл ажиллагааг нээх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, “г”, 29.1.6-ын “л” заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 23 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирус /сovid-19/-ийн халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүжгийн дугуйлан, сургалтын төвүүд, Биеийн тамир, спортын газрын спортын ордон, бага заал, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн спортын заалны үйл ажиллагааг нээн ажиллуулсугай.

2.Дээрх байгууллагуудын үйл ажиллагааг нээсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн яамнаас өгч буй шинэ коронавирус /сovid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжүүдийг чанд баримтлан үйлчилгээ үзүүлэхийг тус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар /М.Пүрэвхүү/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/265-Ch  
02 01153